



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ**



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮР ЧАДВАРЫГ  
ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ



## **МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА MNS 6541:2015**

**Салбарын нэр: Хөдөө аж ахуй**

**Мэргэжлийн нэр: Малын бага эмч**

**БОУСА-ийн хөтөлбөрийн индекс:**

**Монголын мэргэшлийн үндэсний хүрээний түвшин: VII**

**УЛААНБААТАР ХОТ  
2019 он**

**Боловсруулсан багийн гишүүд:**

- |    |               |  |
|----|---------------|--|
| 1  | И.Заяат       | “РЭЗ” ХХК, Малын бага эмч                              |
| 2  | Б.Цэрэнсамбуу | “Эко констракшн” ХХК, Малын бага эмч                   |
| 3  | Т.Оюунцэцэг   | “Чандмань оточ” ХХК, Малын бага эмч                    |
| 4  | С.Бат-Өлзий   | “Уламмандах” ХХК, Малын бага эмч                       |
| 5  | Д.Мягмарсүрэн | “Нөхөрлөл ирээдүй” ХХК, Малын бага эмч                 |
| 6  | Д.Мөнхбаяр    | “Буянхөхий” ХХК, Малын бага эмч                        |
| 7  | Т.Даваа       | Мал эмнэлэгийн ариун цэврийн лабортори, Малын бага эмч |
| 8  | Ч.Батчулуун   | Төв аймгийн Лүн сум, Малын бага эмч                    |
| 9  | Г.Гүндмаа     | Өмнөговь аймгийн Ханхонгор сум, Малын их эмч           |
| 10 | С.Бямбаа      | “Хот ачит хайрхан” ХХК, Малын их эмч                   |

**Хянасан: ХНХЯ болон хөдөө аж ахуйн салбарын экспертүүдийн төлөөлөл**

- |   |              |   |
|---|--------------|---|
| 1 | Д.Адилбиш    | ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн                    |
| 2 | М.Мөнхжаргал | "Овоот гол" ХХК, Малын эмч                              |
| 3 | Д.Энхжаргал  | Дорнод аймаг дахь ПТК, "Малын бага эмч" мэргэжлийн багш |
| 4 | Ц.Сэрвэд     | Ховд аймаг дахь ПТК, "Малын бага эмч" мэргэжлийн багш   |

**ДАКУМ чиглүүлэгч:**

- |   |              |                       |
|---|--------------|-----------------------|
| 1 | Ч.Эрдэнэтуяа | ДАКУМ чиглүүлэгч багш |
|---|--------------|-----------------------|

**Зөвлөхүүд:**

- |   |             |   |
|---|-------------|---|
| 1 | Д.Энхбаатар | ЧССҮ-ний Үндэсний зөвлөх                              |
| 2 | Ц.Ганчимэг  | АХБ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ЧССҮ-ний Мэргэжилтэн |
| 3 | Г.Батчимэг  | ЧССҮ-ний Зөвлөх                                       |

	<b>АГУУЛГА</b>	<b>Хуудас</b>
	Өмнөх үг	4
1	Зорилго	5
2	Хамрах хүрээ	5
3	Норматив ишлэл	5
4	Нэр томъёо, тодорхойлолт	6
5	Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавигдах шаардлага	9
	5.1 Сургалтын агуулга	9
	5.2 Сургалтын хугацаа	31
6	Суралцах хэлбэр	31
7	Сургалтын үнэлгээнд тавигдах шаардлага	31
8	Малын бага эмч мэргэжлээр элсэгчдэд тавигдах шаардлага	32
9	Багшид тавигдах шаардлага	32
10	Сургалтын орчинд тавигдах шаардлага	33
11	Сургалтын тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн жагсаалт	34
12	Номын сан, мэдээллийн хангамжид тавигдах шаардлага	38
13	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага	38
14	Стандартад хэрэглэсэн товчилсон үгийн тайлбар	38

## ӨМНӨХ ҮГ

Хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Малын бага эмч” мэргэжлээр Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлагыг боловсруулав.

Энэхүү “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага”-ыг барилгын засал чимэглэлчид болон ажил олгогчид, чадамжид суурилсан сургалт, үнэлгээний олон улсын зөвлөх, үндэсний зөвлөх, салбарын багш нарын төлөөллийг оролцуулан ДАКУМ арга зүйгээр боловсруулсан ажил мэргэжлийн лавлахад үндэслэн ажилбар, үүрэг нэг бүрээр чадамжийн дүн шинжилгээ хийж боловсруулсан болно.

Мэргэжлийн боловсрол, сургалт нь төр, хувийн хэвшлийн бодит түншлэл, шинэ технологи, шилдэг сургалтын арга зүйд тулгуурлан хөгжиж, өндөр ур чадвартай мэргэжилтэй ажилтнууд төрөн гарч, үйлдвэрлэгч, бүтээгч улс болж, хөгжих болтугай.

## **1. Зорилго**

Энэхүү стандартын зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагыг хангахуйц, мэргэшлийн түвшний тогтолцоотой уялдсан уян хатан сургалтыг “Малын бага эмч” мэргэжлээр зохион байгуулах мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, орчин, багшийн мэргэшил, үнэлгээнд тавигдах үндсэн шаардлагыг тогтооход оршино.

## **2. Хамрах хүрээ**

Энэхүү стандартыг “Малын бага эмч” мэргэжлээр мэргэжлийн боловсрол, сургалт эрхлэн явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, багш, суралцагч, судлаач, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаарх төрийн удирдлага, аргазүй, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэнэ.

## **3. Норматив ишлэл**

Энэхүү стандартад олон улсын болон үндэсний стандарт, баримт бичгийг иш татаж хэрэглэсэн болно. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1 MNS 1-1:2006 Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг
- 3.2 MNS 1-2:2006 Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг
- 3.3 MNS 5742:2007 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага
- 3.4 MNS 5566:2005 Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн норм
- 3.5 MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
- 3.6 MNS 5545 “Мал эмнэлэгийн эмийн сангийн бүтэц үйл ажиллагаа”
- 3.7 MNS 4990 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”
- 3.8 MNS 4244 “Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага”
- 3.9 MNS 900 Ундны ус. “Эрүүл ахуйн хяналт, түүнд тавигдах шаардлага”
- 3.10 MNS 5140 “Баримт бичиг. Баримт бичгийн нэр төрөл, тодорхойлт”
- 3.11 MNS 5141 “Баримт бичиг. Баримт бичгийн бүрдлүүд, тэдгээрт тавигдах шаардлага”
- 3.12 MNS 2010 Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагааны стандарт
- 3.13 MNS 6036 Мал аж ахуй. Ичмэл үр хөврөл өсгөвөрлөх. Ерөнхий шаардлага
- 3.14 MNS 6037 Мал аж ахуй. Үр хөврөл ичээлж хадгалах. Ерөнхий шаардлага
- 3.15 MNS 6196 Үнээ хонь, ямааны үр хөврөл угаах, шилжүүлэн суулгах. Ерөнхий шаардлага
- 3.16 MNS 5368:2011 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага
- 3.17 MNS 5545:2005 Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа
- 3.18 MNS 6035:2009 Мал эмнэлэг. Мах, махан бүтээгдэхүүн. Магадлан шинжилгээний цомог. Техникийн шаардлага

- 3.19 MNS 6269:2011 Малын гаралтай бүтээгдэхүүн. Сүүний шинжилгээнд хэрэглэх урвалж. Техникийн шаардлага
- 3.20 MNS 4386:1996 Цусан халдвар өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.21 MNS 4381:1996 Цусны ийлдсэнд уургийн задрагийг спектоколориметрийн аргаар тодорхойлох арга
- 3.22 MNS 4389:1996 Стрептококийн халдвар үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.23 MNS JIS K0883:2005 Мал эмнэлэг Хонь, ямааг сохор доголоос сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин. Техникийн шаардлага
- 3.24 MNS 6015:2009 Мал эмнэлэг. Хонь, ямааг дотрын халдварт хордлого, брадзот, цусан суулгаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн хам вакцин. Техникийн шаардлага
- 3.25 MNS 4939:2000 Ямааны цэцэг өвчнийг эсэргүүцэх хөнгөн цагааны усан исэлт формалинт вакцин Техникийн шаардлага
- 3.26 MNS 6012:2009 Мал эмнэлэг. Үхрийг боом, дуут хавдраас сэргийлэх амьд вакцин. Техникийн шаардлага
- 3.27 MNS 6085:2010 Мал эмнэлэг. Гахайн колибактериоз, салмонеллёзоос сэргийлэх хам вакцин
- 3.28 MNS 4380:1996 Мал, амьтны эгэл биетэн, цусны паразитаар үүсдэг өвчнийг оношлох арга
- 3.29 MNS 4395:1996 Иж сүрьеэгийн үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.30 MNS 4394:1996 Адууны сахуу өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.31 MNS 4391:1996 Зогсоо өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.32 MNS 4306:1996 Малын туузан хорхойг устгах бэлдмэл- “ЗНК” Antliment “ZNK” preparat
- 3.33 MNS 4387:1996 Ям өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.34 MNS 4386 :1996 Цусан халдвар өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.35 MNS 5199:2002 Адууны трипаносомоз өвчнийг оношлох шинжилгээний арга
- 3.36 MNS 5201:2002 Мал, амьтны иж балнад. Ийлдэс оношлогооны арга
- 3.37 MNS 5202:2002 Үхрийн кампилобактериоз. Ийлдэс оношлогооны арга Наалдуулах урвал
- 3.38 MNS 4374:1996 Некробактериозын үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.39 MNS 4385:1996 Дуут хавдар өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.40 MNS 4390:1996 Дотор халдварт хордлого, хурганы цусан суулга өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.41 MNS 4392:1996 Ёлом өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- 3.42 MNS 4397:1996 Үхрийн лейкозыг оношлох ийлдэс судлалын оношлох шинжилгээний арга
- 3.43 MNS 4398:1996 Мал амьтдын галзуу өвчнийг оношлох арга

- 3.44 MNS 5979:2009 Эрүүл мэндийн технологи – Атгаал чөмөгний хугарлын оношлогоо, эмчилгээ
- 3.45 MNS 5979:10:2009 Эрүүл мэндийн технологи – Дунд чөмөгний хугарлын оношлогоо, эмчилгээ
- 3.46 MNS 5979:11:2009 Эрүүл мэндийн технологи – Шилбэний хугарлын оношлогоо, эмчилгээ
- 3.47 MNS 5979:4:2009 Эрүүл мэндийн технологи - Мөрний сурмаг мултралын оношлогоо, эмчилгээ
- 3.48 MNS 5911:2008 Малын эмнэлэг. Мал тэнхрүүлэх бэлдмэл-3. Техникийн шаардлага
- 3.49 MNS 4373:1996 Өвчтэй ба үхсэн малын махыг ялган тогтоох аргууд
- 3.50 MNS 5198-2002 Мал амьтны бруцеллёз. Ийлдэс судлалын шинжилгээний арга

#### **4. Нэр томъёо, тодорхойлолт**

##### **4.1**

##### **албан боловсрол**

боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагааг;

##### **4.2**

##### **мэргэжил**

тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

##### **4.3**

##### **мэргэшил**

тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг;

##### **4.4**

##### **мэргэжлийн боловсрол**

тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

##### **4.5**

##### **техникийн боловсрол**

техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

#### **4.6**

##### **мэргэжлийн суурь чадвар**

нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшлийг;

#### **4.7**

##### **мэргэшлийн түвшин**

ажилтны эзэмших мэдлэг, чадвар, гүйцэтгэх ажил үүргийн төлөвшил, хариуцлага, хандлагын хүрээг стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг;

#### **4.8**

##### **чадамжид суурилсан сургалт**

мэргэжлийн боловсрол, сургалтаар ажлын байранд тухайн ажлыг ажил мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэхийн тулд эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох, төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт;

#### **4.9**

##### **чадамжид суурилсан үнэлгээ**

суралцагч ажил, үүргийг мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлэн зөв, нямбай хийж гүйцэтгэж байгаа эсэхийг чадамжийн нэгжийн хүрээнд боловсруулсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу нотолгоонд суурилан үнэлгээ хийж, баримтжуулах үйл явц;

#### **4.10**

##### **чадамж**

хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавигдах мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

#### **4.11**

##### **чадамжийн нэгж**

үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг гүйцэтгэлийн үнэлэмжийн хамгийн бага нэгж бөгөөд ихэвчлэн үр дүнгээр хэмжигддэг. Тодорхой ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг;

#### **4.12**

##### **чадамжийн элемент**

чадамжийн нэгжийн дагуу гүйцэтгэх ёстой ажлын гол хэсгүүд буюу ажилбарыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай гол үе шатууд. Элементүүд нь тодорхой ажлыг гүйцэтгэхэд хэрэгцээтэй үйлдлүүдийг тодорхойлдог;

#### **4.13**

##### **гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**

чадамжийн нэгж болон элементүүдийг тавигдсан стандартын дагуу гүйцэтгэх шалгуур;



#### **4.14**

##### **үнэлгээний төлөвлөгөө**

зорилтот бүлгийг ямар чадамжийн нэгжийн шалгуур үзүүлэлтийн дагуу хэзээ, хаана, хэрхэн яаж үнэлэхийг төлөвлөсөн баримт бичиг;

#### **4.15**

##### **чадамжийн нэгжийн үнэлгээ**

тухайн хувь хүн чадамжийн стандартыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд нотлох материал, мэдээлэл цуглуулж холбогдох үнэлэлт, дүгнэлт гаргах үйл явц;

#### **4.16**

##### **чадамжийн багц**

ажилтан мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлж, хөдөлмөрийн чиг үүргийн чанартай гүйцэтгэлийг хангахад шаардагдах мэдлэг, чадвар, туршлага харилцааны багц;

#### **4.17**

##### **багц цаг**

дээд болон мэргэжлийн боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг.

### **5. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавих шаардлага**

#### **5.1 Сургалтын агуулга**

**5.1.1** Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга нь “Малын бага эмч” мэргэжилд хамаарах чадамжийн нэгжүүдээс бүрдэнэ. Чадамжийн нэгжийг “Малын бага эмч” мэргэжлийн ажил мэргэжлийн тодорхойлолтод (лавлах) тусгагдсан мэргэжлийн үүрэг, ажилбаруудад тулгуурлан боловсруулсан болно.

**5.1.2** Ажил мэргэжлийн үүрэг, ажилбаруудыг ДАКУМ (ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх) аргаар тодорхойлж, ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулсан.

**5.1.3** Ажил мэргэжлийн дүн шинжилгээнээс “Малын бага эмч” мэргэжлийн чадамжийн нэгжийн жагсаалтыг тодорхойлж гаргасан. Уг чадамжийн нэгжийн жагсаалтад ороогүй “Малын бага эмч” мэргэжлийн ерөнхий суурь хэсэг болон мэргэжлийн үндсэн ойлголт, онолын мэдлэгийг багш сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

**ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Сургалтын агуулга	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код
1	Мэргэжлийн суурь	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах	АН 3240-17-01-401
2		Ажлын байр бэлтгэх	АН 3240-17-02-401
3		Бичиг баримт боловсруулах	АН 3240-17-03-401
4		Халдварын голомтод ажиллах	АН 3240-17-04-401
5	Мэргэшүүлэх	Мал амьтанд үзлэг хийх	АН 3240-17-05-401
6		Мал амьтанд лабораторийн шинжилгээ хийх	АН 3240-17-06-401
7		Мал амьтны өвчин эмгэгийг оношлох	АН 3240-17-07-401
8		Мал амьтанд жор барих	АН 3240-17-08-401
9		Мал амьтанд эмчилгээ хийх	АН 3240-17-09-401
10		Ариутгал халдваргүйжүүлэлт хийх	АН 3240-17-10-401
11		Өвчнөөс урьдчилсан сэргийлэх	АН 3240-17-11-401

- 5.1.4** “Малын бага эмч” мэргэжил нь Монголын мэргэшлийн үндэсний хүрээний VII түвшинд хамаарах бөгөөд хамаарах чадамжийн нэгж бүрийг эзэмших шаардлагатай.
- 5.1.5** Энэхүү стандартын А хавсралт: А.1-р маягтад дурьдах шаардлагатай “Малын бага эмч” Монголын мэргэшлийн үндэсний хүрээний VII түвшинд харгалзуулах чадамжийн нэгжүүд нь 5.1.3-т зааснаар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд нь А хавсралт: А.3-р маягтад заасны дагуу тодорхойлогдоно.
- 5.1.6** Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн жагсаалтуудыг А хавсралт, А.2-р маягтын дагуу дараах байдлаар боловсруулсан.
- 5.1.7** Чадамжийн нэгж нь чадамжийн элементүүдээс бүрдэнэ. Чадамжийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг А хавсралтын А.3-р маягтын дагуу боловсруулсан. (А хавсралтын А.2, А.3-р маягыг нэгтгэн чадамжийн нэгж бүрээр боловсруулсан.)

**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах
<b>Чадамжийн нэгжийн код:</b> АН 3240-17-01-401
<p><b>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</b></p> <p><b>Эзэмшвэл зохих мэдлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журам, практик хэрэглээ</li> <li>• Хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, тэдгээрийн ашиглалт</li> <li>• ХАБЭА-н шаардлага, стандарт мөрдөх</li> <li>• Тайлагнах болон мэдээллэх</li> <li>• Аюул, эрсдлийг тодорхойлж, хянах</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзүүлэлтүүд</li> <li>• Байгууллагын аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам</li> </ul> <p><b>Эзэмшвэл зохих ур чадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хувийн ариун цэврийг сахих</li> <li>• Аюул, эрсдлийг тодорхойлж, хянах</li> <li>• Бусадтай харилцах</li> <li>• Мэдээлэл харилцааны бусад</li> <li>• Ажлын байрыг бэлтгэх</li> <li>• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах</li> <li>• Онцгой байдлын үед авах арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>• Анхны тусламж үзүүлэх</li> <li>• Хувийн хамгаалах хэрэгслийг зөв зохистой бүрэн ашиглах</li> <li>• ХАБЭА-н шаардлага стандарт ажлын байранд бүрэн ашиглах</li> <li>• Хамтран ажиллагсад зөв мэдээлэл дамжуулах чадвар</li> <li>• Гадна дотны бүх харилцагчтайгаа хүндэтгэлтэй, зөв боловсон, шударга харилцах чадвар</li> </ul> <p><b>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Аюулгүй байдлыг хангах</li> <li>• Эрүүл ахуйг хангах</li> <li>• Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших</li> <li>• Хувийн ариун цэврийг сахих</li> <li>• Суралцах соёл.</li> <li>• Хөдөлмөрийн сахилгатай</li> <li>• Нягт нямбай, цэвэрч</li> <li>• Мэргэжилдээ сонирхолтой</li> <li>• Идэвхи санаачлагатай</li> <li>• Хариуцлагатай</li> <li>• Хувийн зохион байгуулалттай</li> </ul>

<b>Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	
<b>ЭЛЕМЕНТ</b>	<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>
ЧЭ 1. ХАБЭА-н үндсэн ойлголт ба хууль эрх зүйн орчин	ГШҮ 1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн бүтэц, агуулгатай танилцах
	ГШҮ 1.2 ХАБЭА-д холбогдох эрх зүйн бусад баримт бичигтэй танилцах.
	ГШҮ 1.3 ХАБЭА-н тухай хууль тогтоомж болон бусад шаардлагыг зөрчих, түүний үр дагавартай танилцах.
	ГШҮ1.4 Хамгаалах техник, хувийн ба тусгай хамгаалах хэрэгсэлтэй танилцах
	ГШҮ1.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа, аюулгүйн тэмдэг тэмдэглэгээтэй танилцах
ЧЭ 2. Ажлын байрыг зөв зохион байгуулах	ГШҮ 2.1 Ажлын байран дахь осол, гал түймэр, онцгой байдлын үед сахих дүрэм журмыг байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, бодлогод уялдуулан дагаж мөрдөх.
	ГШҮ 2.2 Ажлын байрны шаардлага стандарт хангаж ажиллах
	ГШҮ 2.3 Аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу багаж хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах
ЧЭ 3. Ажлын байрны аюулыг илрүүлэх болон эрсдэлийн үнэлгээнд оролцох	ГШҮ 3.1 Ажлын байрны аюулыг тодорхойлох, тохиромжтой арга барил сонгоход оролцох
	ГШҮ 3.2 Аюулыг илрүүлж байгаа ажилтанг тусламж, мэдээллээр хангах
	ГШҮ 3.3 Ажлын байрны эрсдэлийн үнэлгээний тохиромжтой арга сонгоход оролцох
	ГШҮ 3.4 Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа ажилтанг тусламж, мэдээллээр хангах
ЧЭ 4. Хөдөлмөрийн, аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах	ГШҮ 4.1 Хувийн хамгаалах хэрэгслийг байгууллагын заавар чиглэл, дүрэм журамд нийцүүлэн ашиглах
	ГШҮ 4.2 Ажлын байранд тавигдах шаардлагын дагуу хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын хувийн хэргийг бөглөх
	ГШҮ 4.3 Онцгой байдалтай холбоотой дасгал, сургуулилтын үед баримтлах дүрэм журмыг байгууллагын тогтсон заавар чиглэл, дүрэм журамд нийцүүлэн зүй зохистой дагаж мөрдөх
ЧЭ 5. Шаардлагатай нөхцөлд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх	ГШҮ 5.1 Ажлын байран дахь яаралтай тусламжийн үед туслалцаа үзүүлэхтэй холбоотой дүрэм журмыг байгууллагын тогтсон дэг журамд нийцүүлэн тодорхойлох
	ГШҮ 5.2 Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх арга барил, аргачлалыг судлах.
	ГШҮ 5.3 Дасгал сургуулилтын явцад зөв аргаар цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх

**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Ажлын байр бэлтгэх
<b>Чадамжийн нэгжийн код:</b> АН 3240-17-01-401
<p><b>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</b></p> <p><b>Эзэмшвэл зохих мэдлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны явцад ХАБЭА-н хэм хэмжээг сахиж, мөрдөж ажиллах,</li> <li>• Ажлын байрны аюул эрсдэлийн дүн шинжилгээ хийж, тохиолдох эрсдэлүүдийг тооцон зайлуулах, холбогдох</li> <li>• Тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллах нөхцлийг хангах</li> <li>• Байгаль орчны бохирдлоос сэргийлэх мэдлэг эзэмшинэ</li> </ul> <p><b>Эзэмшвэл зохих ур чадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Аюулгүй ажиллагааны зааварчилга авах</li> <li>• Аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах</li> <li>• Тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх</li> <li>• Ажлын байрыг цэвэрлэх</li> <li>• Хог хаягдлыг устгах</li> </ul> <p><b>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сахилга бат, хариуцлагатай байх</li> <li>• Үнэнч, шударга</li> <li>• Ажлын цаг баримталдаг</li> <li>• Багаар ажиллах</li> <li>• Бие даан ажиллах</li> <li>• Мал, амьтантай тай зөв харьцах</li> <li>• Нягт, нямбай байх</li> <li>• Хувийн бэлтгэл хангасан</li> </ul>

<b>Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	
<b>ЭЛЕМЕНТ</b>	<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>
ЧЭ 1. Аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах	ГШҮ 1.1 Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах
	ГШҮ 1.2 Хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх
	ГШҮ 1.3 Аюулын байрны эрсдэл үнэлэх
	ГШҮ 1.4 Ажлын байрны аюулгүй байдлыг бүрдүүлэх
	ГШҮ 1.5 Хэрэглэсэн нэг удаагийн материал, хэрэгслийг устгах, цэвэрлэх
	ГШҮ 1.6 Багаж тоног төхөөрөмжийн эрүүл аюулгүй байдлыг хангах
	ГШҮ 1.7 Онцгой байдлын үед аюулгүй ажиллах
ЧЭ 2. Тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх	ГШҮ 2.1 Тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгах
	ГШҮ 2.2 Тоног төхөөрөмжинд засвар, үйлчилгээ хийх
	ГШҮ 2.3 Тоног төхөөрөмжийг ариутгах, цэвэрлэх

	ГШҮ 2.4 Тоног төхөөрөмжийн ашиглалтын гэрчилгээнд бичилт хийх
	ГШҮ 2.5 Тоног төхөөрөмжийг ажиллуулах
	ГШҮ 2.6 Тоног төхөөрөмжийг салгаж цэвэрлэж байрлуулах
ЧЭ 3. Ажлын байрыг цэвэрлэх	ГШҮ 3.1 Тухайн ажлын байран дахь үйл ажиллагаа дууссаныг мэдэгдэх
	ГШҮ 3.2 Ажлын байран дахь тоног төхөөрөмж багаж хэрэгслийг хурааж авах
	ГШҮ 3.3 Ажлын байранд цэвэрлэгээ хийх
	ГШҮ 3.4 Ажлын байранд ариутгал, хийх
	ГШҮ 3.5 Ажлын байран дахь эд хогшлын бүртгэл хөтлөх
	ГШҮ 3.6 Ажлын байрыг дараагийн ажилд бэлэн болгож хүлээлгэж өгөх
ЧЭ 4. Хог хаягдлыг устгах	ГШҮ 4.1 Хог хаягдлын устгалын цэг байгуулах
	ГШҮ 4.2 Хог хаягдлыг горимын дагуу устгах
	ГШҮ 4.3 Халдвараар өвчилсөн малыг горимын дагуу устгах
	ГШҮ 4.4 Үхсэн хорогдсон малд акт гаргах
	ГШҮ 4.5 Хог хаягдал устгалын цэгийг ариутгах

**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Бичиг баримт боловсруулах
<b>Чадамжийн нэгжийн код:</b> АН 3240-17-09-401
<b>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</b>
<p><b>Эзэмшвэл зохих мэдлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Мал эмнэлэгийн мэдээ тайланг боловсруулах</li> <li>• Албан бичиг боловсруулах</li> <li>• Төрийн байгууллагаас баталсан албан ёсны маягт зааврын дагуу гаргах</li> <li>• Мал эмнэлэгийн анхан шатны бүртгэлийг хөтлөх</li> </ul> <p><b>Эзэмшвэл зохих ур чадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Мал эмнэлэгийн мэдээ гаргах</li> <li>• Мал эмнэлэгийн тайлан бичих</li> <li>• Акт бичих</li> <li>• Ариун цэврийн гэрчилгээ бичих</li> <li>• Өрхийн малын эрүүл мэндийн дэвтэр хөтлөх</li> <li>• Өвчлөлийн түүх хөтлөх</li> </ul> <p><b>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сахилга бат, хариуцлагатай байх</li> <li>• Үнэнч, шударга</li> <li>• Ажлын цаг баримталдаг</li> <li>• Багаар ажиллах</li> <li>• Бие даан ажиллах</li> <li>• Мал, амьтантай тай зөв харьцах</li> <li>• Нягт, нямбай байх</li> <li>• Хувийн бэлтгэл хангасан</li> </ul>

<b>Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	
<b>ЭЛЕМЕНТ</b>	<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>
ЧЭ 1. Мал эмнэлэгийн мэдээ гаргах	ГШҮ 1.1 Мал амьтны халдварт паразиттах өвчний арга хэмжээний жургал гаргах
	ГШҮ 1.2 Ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээний журнал гаргах
	ГШҮ 1.3 Тарилга туулгалт халдваргүйжүүлэлтийн акт хөтлөх
ЧЭ 2. Анхан шатны бүртгэл хөтлөх	ГШҮ 2.1 Мал эмнэлэгийн гарал үүсэл ариун цэврийн гэрчилгээ хөтлөх
	ГШҮ 2.2 Өвчний түүх хөтлөх
	ГШҮ 2.3 Эмгэг анатомийн задлалтын протокол хөтлөх

**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Халдварын голомтонд ажиллах
<b>Чадамжийн нэгжийн код:</b> АН 3240-17-10-40
<p><b>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</b></p> <p><b>Эзэмшвэл зохих мэдлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Халдварт өвчин үүсэн гарах, дамжин тархах зүй тогтол,</li> <li>• Халдварт өвчин гарсан тохиолдолд ажиллах зарчим, түүнтэй тэмцэх,</li> <li>• Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудыг мэддэг болох</li> </ul> <p><b>Эзэмшвэл зохих ур чадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Халдварын голомтонд мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх,</li> <li>• Халдварыг дамжин тархахаас сэргийлж ажиллах</li> <li>• Халдварт өвчний голомтын байршил тогтоох</li> <li>• Халдварт өвчний голомтын хил, хязгаар тогтоох</li> <li>• Хяналтын цэг байгуулах</li> <li>• Устгалын цэгийг халдваргүйжүүлэх</li> <li>• Хорио цээрийг буулгах</li> </ul> <p><b>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сахилга бат, хариуцлагатай байх</li> <li>• Үнэнч, шударга</li> <li>• Ажлын цаг баримталдаг</li> <li>• Багаар ажиллах</li> <li>• Бие даан ажиллах</li> <li>• Мал, амьтантай тай зөв харьцах</li> <li>• Нягт, нямбай байх</li> <li>• Хувийн бэлтгэл хангасан</li> </ul>

<b>Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	
<b>ЭЛЕМЕНТ</b>	<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>
ЧЭ 1. Халдварт өвчний голомтын байршил тогтоох	ГШҮ 1.1 Өвчний голомтыг таних, байршилыг тогтоох
	ГШҮ 1.2 Өвчний голомтыг ангилан ялгах
	ГШҮ 1.3 Өвчний голомтын хамаарлыг гаргаж ирэх
ЧЭ 2. Халдварт өвчний голомтын хил, хязгаар тогтоож ажиллах	ГШҮ 2.1 Өвчний голомтын хил хязгаарыг тогтоох
	ГШҮ 2.2 Өвчний голомтын хил хязгаарын чиглэлийг тогтоох
ЧЭ 3. Хяналтын цэг байгуулах	ГШҮ 3.1 Хяналтын цэг байгуулах бэлтгэл ажлыг хангах
	ГШҮ 3.2 Хяналтын цэгийн байгуулах
	ГШҮ 3.3 Хяналтын цэгт ажиллах
ЧЭ 4. Устгалын цэгийг халдваргүйжүүлэх	ГШҮ 4.1 Устгалын цэг байгуулах бэлтгэл ажлыг хангах
	ГШҮ 4.2 Устгалын цэгийг байрлуулах
	ГШҮ 4.3 Устгалын цэг халдваргүйжүүлэх
ЧЭ 5. Хорио цээрийг буулгах	ГШҮ 5.1 Хорио цээр буулгах бэлтгэл ажлыг хангах
	ГШҮ 5.2 Хяналтын цэгийг буулгах



**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Мал амьтанд үзлэг хийх
<b>Чадамжийн нэгжийн код:</b> АН 3240-17-05 -401
<p><b>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</b></p> <p><b>Эзэмшвэл зохих мэдлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинжилгээний аргуудаар шинжлэн мал амьтанд үзлэг хийх</li> <li>• Өвчин эмгэгүүдийг ялган таних, шинжилгээний аргуудад судлах</li> <li>• Мал амьтны эмгэг өөрчлөлтийг илрүүлэн оношлох.</li> </ul> <p><b>Эзэмшвэл зохих ур чадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Мал амьтанд гадна үзлэг хийх</li> <li>• Мал амьтанд арьс, салст бүрхэвчийн үзлэг хийх</li> <li>• Мал амьтны биеийн халууныг хэмжих</li> <li>• Мал амьтанд чагнах үзлэг хийх</li> <li>• Мал амьтанд гараар үзлэг хийх</li> <li>• Мал амьтны мэдрэхүйд үзлэг хийх</li> </ul> <p><b>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сахилга бат, хариуцлагатай байх</li> <li>• Үнэнч, шударга</li> <li>• Ажлын цаг баримталдаг</li> <li>• Багаар ажиллах</li> <li>• Бие даан ажиллах</li> <li>• Мал, амьтантай тай зөв харьцах</li> <li>• Нягт, нямбай байх</li> <li>• Хувийн бэлтгэл хангасан</li> </ul>

**Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Мал амьтанд гадна үзлэг хийх	ГШҮ 1.1 Мал, амьтны биеийн тодорхой хэсгүүдэд гадна үзлэгийг хийх
	ГШҮ 1.2 Мал, амьтны биеийн бүх хэсгүүдэд гадна үзлэгийг хийх
	ГШҮ 1.3 Мал, амьтны зан авирыг тодорхойлох
	ГШҮ 1.4 Мал, амьтны орон зай дахь биеийн байрлалыг тогтоох
	ГШҮ 2.1 Мал, амьтанг сонгож авах, байрлуулах

ЧЭ 2. Мал амьтанд арьс, салст бүрхэвчийн үзлэг хийх	ГШҮ 2.2 Мал амьтны арьс, салст бүрхэвч, тунгалагийн зангилааг харах аргаар үзлэг хийх
	ГШҮ 2.3 Мал амьтны арьс, салст бүрхэвч, тунгалагийн зангилааг барилах аргаар үзлэг хийх
	ГШҮ 2.4 Мал амьтны арьс, салст бүрхэвч, тунгалагийн зангилаанаас сорьц авч бэлтгэх
ЧЭ 3. Мал амьтны биеийн халууныг хэмжих	ГШҮ 3.1 Мал, амьтны хөдөлгөөнийг хязгаарлаж бэхлэх
	ГШҮ 3.2 Хэрэглэгдэх багаж, материалыг сонгож авах
	ГШҮ 3.3 Мал амьтны биеийн халууныг шинжилж, халууны хуудас дээр тахирмаг гаргах
ЧЭ 4. Мал амьтанд чагнах үзлэг хийх	ГШҮ 4.1 Чагнуурыг ашиглаж үзлэг хийх
	ГШҮ 4.2 Мал амьтныг шууд чагнах аргаар шинжлэх
	ГШҮ 4.3 Мал амьтныг шууд бус чагнах аргаар шинжлэх
ЧЭ 5. Мал амьтанд барилах үзлэг хийх	ГШҮ 5.1 Мал амьтныг шууд тогших аргаар үзлэг хийх
	ГШҮ 5.2 Мал амьтныг тэмтрэх аргаар үзлэг хийх
	ГШҮ 5.3 Мал амьтныг гүн барилах аргаар үзлэг хийх
	ГШҮ 5.4 Мал амьтныг шулуун гэдсээр барилах аргаар үзлэг хийх
ЧЭ 6. Мал амьтны мэдрэхүйд үзлэг хийх	ГШҮ 6.1 Мал амьтны хөдөлгөөний мэдрэхүйд үзлэг хийх
	ГШҮ 6.2 Мал амьтны хүрэлцэх мэдрэхүйд үзлэг хийх
	ГШҮ 6.3 Мал амьтны сонсох мэдрэхүйд үзлэг хийх
	ГШҮ 6.4 Мал амьтны амтлах, үнэрлэх мэдрэхүйд үзлэг хийх
	ГШҮ 6.5 Мал амьтны харах мэдрэхүйд үзлэг хийх

**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Мал амьтанд лабораторийн шинжилгээ хийх
<b>Чадамжийн нэгжийн код:</b> АН 3240-17-06-401
<b>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</b>
<p><b>Эзэмшвэл зохих мэдлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Лабораторийн тоноглол, эрүүл ахуй ариун цэврийн шаардлага</li> <li>• Лабораторит ажиллах аюулгүй ажиллагаа</li> <li>• Лабораторит дээж авах, бэхжүүлэх, илгээх ерөнхий зарчим</li> <li>• Стандарт, заавар, арга зүйн талаарх мэдлэг</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үзүүлэлтүүд</li> <li>• Байгууллагын аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам</li> </ul> <p><b>Эзэмшвэл зохих ур чадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Лабораторт ажиллах чадвар</li> <li>• Лабораторт дээж авч илгээх</li> <li>• Бусадтай харилцах</li> <li>• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах</li> <li>• Шинжилгээний онцлогт тохируулан сонголт хийх чадвар эзэмших</li> </ul> <p><b>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Аюулгүй байдлыг хангах</li> <li>• Эрүүл ахуйг хангах</li> <li>• Хувийн ариун цэврийг сахих</li> <li>• Суралцах соёл.</li> <li>• Хөдөлмөрийн сахилгатай</li> <li>• Нягт нямбай , цэвэрч</li> <li>• Мэргэжилдээ сонирхолтой</li> <li>• Идэвхи санаачлагатай</li> <li>• Хариуцлагатай</li> <li>• Хувийн зохион байгуулалттай</li> </ul>

**Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Мал амьтны эдээс дээж авах	ГШҮ 1.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 1.2 Шархнаас сорьц авах
	ГШҮ 1.3 Шулуун гэдэснээс арчдас авах
	ГШҮ 1.4 Эмгэгт эдээс дээж авах
ЧЭ 2. Мал амьтны цуснаас дээж авах	ГШҮ 2.1.Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 2.2 Цусыг авах
	ГШҮ 2.3 Цусыг хадгалах
	ГШҮ 2.5 Цусыг лабораторит хүргүүлэх
	ГШҮ 3.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 3.2 Баас шинжлэх

ЧЭ 3. Мал, амьтны ялгадсанд шинжилгээ хийх	ГШҮ 3.3 Шээс шинжлэх
ЧЭ 4. Мал, амьтны арьс, салстанд шинжилгээ хийх	ГШҮ 4.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 4.2 Арьсанд шинжилгээг хийх
	ГШҮ 4.3 Салст бүрхэвчинд шинжилгээ хийх
ЧЭ 5. Малын сүүнд шинжилгээ хийх	ГШҮ 5.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 5.2 Сүүнд мэдрэхүйн эрхтэний шинжилгээ хийх
	ГШҮ 5.3 Сүүний хольцыг тодорхойлох
	ГШҮ 5.4 Сүүний Ph тодорхойлох
	ГШҮ 5.5 Сүүнд бруцеллёзын цагирган урвалын шинжилгээ хийх
	ГШҮ 5.6 Дэлэнгийн үрэвсэл тодорхойлох
ЧЭ 6. Малын маханд шинжилгээ хийх	ГШҮ 6.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 6.2 Маханд мэдэрхүйн эрхтний үзлэг хийх
	ГШҮ 6.3 Махны рН тодорхойлох
ЧЭ 7. Малын амьдрах орчноос дээж авах	ГШҮ 7.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 7.2 Уснаас дээж авах
	ГШҮ 7.3 Хөрснөөс дээж авах
	ГШҮ 7.4 Тэжээлээс дээж авах
ЧЭ 8. Мал, амьтдын түүхий эдэд шинжилгээ хийх	ГШҮ 8.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 8.2 Арьс, шир шинжлэх
	ГШҮ 8.3 Ноос, ноолуур шинжлэх
	ГШҮ 8.4 Өлөн гэдэс шинжлэх
ЧЭ 9. Зөгийн баланд шинжилгээ хийх	ГШҮ 9.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 9.2 Зөгийн балны чанарыг мэдрэхүйн эрхтнээр тодорхойлох
	ГШҮ 9.3 Зөгийн балны РН \хүчиллэг\ тодорхойлох
ЧЭ 10. Өндгөнд шинжилгээ хийх	ГШҮ 10.1 Ашиглах багаж, хэрэгсэл сонгож авах
	ГШҮ 10.2 Өндгөнд мэдрэхүйн эрхтний шинжилгээ хийх
	ГШҮ 10.3 Өндгийг овоскопоор шинжлэх

**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Мал амьтны өвчин эмгэгийг оношлох
<b>Чадамжийн нэгжийн код:</b> АН 3240-17-07-401
<p><b>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</b></p> <p><b>Эзэмшвэл зохих мэдлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Лабораторийн тоноглол, эрүүл ахуй ариун цэврийн шаардлага</li> <li>• Лабораторит ажиллах аюулгүй ажиллагаа</li> <li>• Лабораторит дээж авах, бэхжүүлэх, илгээх ерөнхий зарчим</li> <li>• Стандарт, заавар, арга зүйн талаарх мэдлэг</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үзүүлэлтүүд</li> <li>• Байгууллагын аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам</li> </ul> <p><b>Эзэмшвэл зохих ур чадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Лабораторит ажиллах чадвар</li> <li>• Лабораторит дээж авч илгээх</li> <li>• Бусадтай харилцах</li> <li>• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах</li> <li>• Шинжилгээний онцлогт тохируулан сонголт хийх чадвар эзэмших</li> </ul> <p><b>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Аюулгүй байдлыг хангах</li> <li>• Эрүүл ахуйг хангах</li> <li>• Хувийн ариун цэврийг сахих</li> <li>• Суралцах соёл</li> <li>• Хөдөлмөрийн сахилгатай</li> <li>• Нягт нямбай, цэвэрч</li> <li>• Мэргэжилдээ сонирхолтой</li> <li>• Идэвхи санаачлагатай</li> <li>• Хариуцлагатай</li> <li>• Хувийн зохион байгуулалттай</li> </ul>

**Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Тусгай шинжилгээнд мал, амьтанг бэлтгэх	ГШҮ 1.1 Мал, амьтанг ЭХО шинжилгээнд бэлтгэх
	ГШҮ 1.2 Мал, амьтанг РЕНТГЕН шинжилгээнд бэлтгэх
ЧЭ 2. Мал, амьтны өвчнийг шинж тэмдгээр оношлох	ГШҮ 2.1 Зүрх судасны өвчин эмгэгийг оношлох
	ГШҮ 2.2 Амьсгалын замын өвчин эмгэгийг оношлох
	ГШҮ 2.3 Тэжээл боловсруулах замын өвчин эмгэгийг оношлох
	ГШҮ 2.4 Бодисын солилцооны өвчин эмгэгийг оношлох
	ГШҮ 2.5 Шээс, үржлийн замын өвчин эмгэгийг оношлох
	ГШҮ 2.5 Мэдрэлийн өвчин эмгэгийг оношлох
	ГШҮ 3.1 Хачгаар үүсдэг паразит өвчнийг оношлох

ЧЭ 3. Малын паразитыг оношлох	ГШҮ 3.2 Нематодоор үүсдэг паразит өвчнийг оношлох
	ГШҮ 3.3 Цестодоор үүсдэг паразит өвчнийг оношлох
	ГШҮ 3.4 Трематодоор үүсдэг паразит өвчнийг оношлох
	ГШҮ 3.5 Эгэл биетнээр үүсдэг паразит өвчнийг оношлох
ЧЭ 4. Малын халдварт өвчнийг хурдавчилсан оношлуураар оношлох	ГШҮ 4.1 Боомыг хурдавчилсан урвалаар оношлох
	ГШҮ 4.2 Галзуу өвчнийг хурдавчилсан урвалаар оношлох
	ГШҮ 4.3 Ям өвчнийг сорил тавьж оношлох
	ГШҮ 4.4 Сүрьеэ өвчнийг хурдавчилсан урвалаар оношлох
ЧЭ 5. Мал амьтанд задлан шинжилгээ хийх	ГШҮ 5.1 Хүүрэнд гадны үзлэг хийх
	ГШҮ 5.2 Хүүрийг “бүрэн задалгааны арга”-аар задлах
	ГШҮ 5.3 Хүүрийг “бүрэн бус задалгааны арга”-аар задлах
	ГШҮ 5.4 Хүүр задлалтын тэмдэглэл хөтлөх

**Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага**

<b>ТҮВШИН VII</b>
<b>Чадамжийн нэгж:</b> Мал амьтанд жор барих
